



YAF
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

БАРИЛГЫН ХӨГЖЛИЙН ТӨВИЙН 2015 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл
дараах хаягаар харилцана уу:

САГ-ын дарга, Тэргүүлэх аудитор
С.Энхзаяа
Утас: 261663
Цахим хаяг: enkhzayas@audit.gov.mn

Аудитын менежер: Ц.Ойдов
Утас: 261885
Цахим хаяг: oidovts@audit.gov.mn

Аудитор: Ж.Болормаа
Утас: 260512
Цахим хаяг: bolormaaj@audit.gov.mn

ТАБ-ын хаяг: Үндэсний аудитын
газар
Байршил: Чингэлтэй дүүрэг
Цахим хуудас: www.audit.mn

2016 оны 2 дугаар сар

Аудитын тайлан

Хавсралт 1: Агуулга

Хавсралт 2: Аудитын гэрчилгээ

Хавсралт 3: Менежментийн захидал

Хавсралт 4: Аудит хийсэн санхүүгийн тайлан

Хавсралт 5: Төсвийн гүйцэтгэлийн тайлан

АГУУЛГА

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Дотоод хяналт
6. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
7. Шилэн дансны мэдээлэл
8. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
9. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар
10. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар
11. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар
12. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
13. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
14. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
15. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
16. Зөвлөмж
17. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт

Нэг. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл

Төсвийн тухай хуулийн 8.9.8, Төрийн аудитын тухай хуулийн 15.1.2 дахь заалтыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 18.2 дүгээр зүйлд заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Барилгын хөгжлийн төвийн 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланда /САГ-2016/1/СТА-УТҮГ/ аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Барилгын хөгжлийн төвийн 2015 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт /НББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Барилгын хөгжлийн төвийн удирдлага санхүүгийн тайлангаа НББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын холбогдох журмууд, нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, шударга бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, НББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Барилгын хөгжлийн төв 2015 оны санхүүгийн тайлангаа 2016 оны 2 дүгээр сарын 18-нд Үндэсний аудитын газарт ирүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасан төсвийн цаглабарын хугацаанаас хоцроосон байна.

Барилгын хөгжлийн төвийн 2015 оны санхүүгийн тайлангийн аудитыг 2016 оны 2 дүгээр сарын 22-наас 3 дугаар сарын 04-ний хооронд хийхээр төлөвлөн Үндэсний аудитын газрын САГ-ын аудитор Ж.Болормаа гүйцэтгэж, аудитын тайланг хуулийн хугацаанд тус төвийн удирдлагад гардуулна.

Хоёр. Байгууллагын хууль, эрх зүйн орчин

Барилгын хөгжлийн төв нь дараах хууль тогтоомж, эрх зүйн баримт бичгүүдийг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллаж байна. Үүнд,

- Төсвийн тухай хууль
- Барилгын тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Шилэн дансны тухай хууль

- Архивын тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Нийгмийн даатгалын тухай хууль
- Татварын тухай хуулиуд зэрэг байна.

Тайлант хугацаанд тухайн байгууллагын үйл ажиллагааг зохицуулж буй гол хууль тогтоомжид өөрчлөлт ороогүй байна.

Гурав. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа

Барилгын хөгжлийн төв нь Барилга угсралт, зураг төсөл, барилгын материалын үйлдвэрлэлийн эрх зүйн орчинг боловсронгуй болгох, барилгын норм, нормативын баримт бичгийг шинээр боловсруулах, шинэчлэх ажлыг зохион байгуулж, мэргэжлийн зөвлөмж, удирдлага, мэдээллээр хангах, хэрэгжилтэд хяналт тавих үйл ажиллагаа эрхэлдэг.

Барилгын салбарын хөгжлийг түргэтгэгч, дэмжин туслагч, түншлэгч байгууллага байна гэсэн эрхэм зорилготой тус байгууллагын үндсэн зорилт нь:

- Барилга угсралт, зураг төсөл, барилгын материалын үйлдвэрлэлийн эрх зүйн орчинг боловсронгуй болгох,
- Барилгын норм, нормативын баримт бичгийг шинээр боловсруулах, шинэчлэх ажлыг зохион байгуулж, мэргэжлийн зөвлөмж, удирдлага, мэдээллээр хангах, хэрэгжилтэд хяналт тавих юм.

Тус төвийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан болно.

Дөрөв. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, НББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар Барилгын хөгжлийн төвийн 2015 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс төвийн удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд нягтлан бодох бүртгэлийн дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансдаас түүвэрлэн аудитын нарийвчилсан горим, сорил 25-ыг гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Тухайн байгууллагын няглан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх няглан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулж мөрдөж ажилласан байна.

Барилгын хөгжлийн төвийн санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг санхүүгийн “Даймонд” програмаар боловсруулж байна.

Мөн санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа мэдээллийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд “бага” буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэж үзсэн байна. /ТАБ-СТА-В-2/

Барилгын хөгжлийн төвийн 2015 оны санхүүгийн тайлангийн материаллаг байдлын үнэлгээг мөнгөн гүйлгээний тайлангийн нийт зардлын 0.5% буюу 50.8 сая төгрөгөөр тогтоов.

Тав. Дотоод хяналт

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Зохицуулах зөвлөлийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үед “дунд” гэж тооцсон боловч дахин хянахад дотоод хяналт хэвийн байна.

Зургаа. Орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар

ТӨХ-ны 2015 оны 4 дүгээр сарын 9-ний өдрийн 218 дугаар тогтоолоор Барилгын хөгжлийн төвийн 2015 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтыг баталсан байна.

Тус тогтоолоор 2015 оны нийт орлогыг 4,820.0 сая төгрөгөөр, нийт зардлыг 4,811.3 сая төгрөгөөр, түүний дотор хөрөнгө оруулалтын зардлыг 83.3 сая төгрөгөөр баталсан байна.

Улсын төсөвт төвлөрүүлэх Нормчлолын сангийн шимтгэлийг 1,100.0 сая төгрөгөөр баталсан боловч 1,050.0 сая төгрөгөөр буюу орлогын төлөвлөгөөг 95.5% биелүүлсэн байна.

2015 оны санхүүгийн тайлангийн Орлогын дэлгэрэнгүй тайлангаар борлуулалтын орлого 5,235.5 сая төгрөг, ерөнхий ба удирдлагын зардал 5,358.7 сая төгрөг тайлагнагдсан бөгөөд 7.6 сая төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна.

Долоо. Шилэн дансны мэдээлэл

Барилгын хөгжлийн төв нь Шилэн дансны тухай хуулийн 5,6,7 дугаар зүйл, Засгийн газрын 2014 оны “Журам батлах тухай” 384 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор өөрийн www.barilqa.gov.mn веб сайтад Шилэн данс цэсийг байршуулж 4,682.2 сая төгрөгийн 288 орлогын гүйлгээ, 2,771.6 сая төгрөгийн 100 зарлагын гүйлгээ нийт 7,453.8 сая төгрөгийн 5 сая төгрөгөөс дээш үнийн дун бүхий ажил гүйлгээг тогтоосон хугацаанд нийтэд мэдээлсэн байна.

Найм. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу уламжлалт болон хяналтын 30 эрсдэлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв. Аудитын явцад дараах гол эрсдэлүүдийг олж тогтоов.

- Барилгын хөгжлийн төвд байгаа Барилгын норм, норматив боловсруулах сангийн 2015 оны үйл ажиллагааны зардлын төлөвлөгөө 734.5 сая төгрөг байгаа нь БХБЯ-ны норм, нормативын хэлтсийн төлөвлөгөөнөөс 265.5 сая төгрөгөөр бага байна.
- Барилгын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2 Барилгын норм, нормативыг боловсруулах сангийн хөрөнгийг норм, нормативын бичиг баримтыг боловсруулах, шинэчлэх зорилгоор зарцуулна гэж заасан боловч БХБСайдын 2015 оны 5 дугаар сарын 15-ны өдрийн 108 дугаар тушаалаар батлагдсан “Барилгын норм, норматив боловсруулах санг бүрдүүлэх, зарцуулах журам”-д сангийн хөрөнгийг зарцуулах арга хэмжээний хамрах хүрээг хуульд зааснаас өргөн болгосон нь зардал нэмэгдэх үндэс болсон байна.

Ес. Гол онцлог гүйлгээний талаарх тайлбар

Барилгын хөгжлийн төвийн 2015 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайландаа нөлөөлөхүйц хэмжээний мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, бараа үйлчилгээний орлого, зардал зэрэг дансанд ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрлэн нарийвчилсан горим, сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/

Тайлант жилд гарсан онцлог гүйлгээг дурдвал:

- Засгийн газрын 2015 оны 2 дугаар сарын 9-ний өдрийн 55 дугаар тогтоолоор “Зураг, төсөл, эрдэм шинжилгээний институт” УТҮГ-ыг тус төвд нэгтгэсэн байна.
- Үүний дагуу ТӨХ-ны 2015 оны 5 дугаар сарын 7-ны өдрийн 297 дугаар тогтоолоор “Зураг, төсөл, эрдэм шинжилгээний институт” УТҮГ-ын эзэмшилд байсан 250 нэр төрлийн 5,274.1 сая төгрөгийн хөрөнгийг тус төвийн балансад шилжүүлсэн байна.
- ТӨХ-ны 2015 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн 498 дугаар тогтоолоор тус байгууллага нь 2014 оны цэвэр ашгаас 927.3 сая төгрөгийн ногдол ашгийг улсын төсөөт төвлөрүүлсэн байна.

Арав. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар

Барилгын хөгжлийн төвийн 2015 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн алдаа, зөрчил болон удирдлагын анхаарал хандуулах гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

1. БХБСайдын 2015 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн 3/3225 дугаартай албан бичгээр Бельгийн Вант Улсад томилолтоор ажиллуулах 41.3 сая төгрөгийн зардал, тус яамны ТНБД-ын 2015 оны 11 дүгээр сарын 19-ний 3/3431 дугаар албан бичгээр ХБНГУ-ын Магдебург хотод томилолтоор ажиллах 30.9 сая төгрөгийн томилолтын зардал нийт 72.3 сая төгрөгийг Норм, нормативын сангийн хөрөнгөөс гаргасан байна.

“Ногоон хотууд-ногоон үйлдвэрлэл” олон улсын хуралд оролцох ажлын айлчлалын бүрэлдэхүүнд Сангийн үйл ажиллагаатай холбоогүй зарим нэг хүмүүс явсан бөгөөд айлчлалын зорилго Барилгын норм, норматив боловсруулах сангийн үйл ажиллагааны зорилготой нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Барилгын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2 Барилгын норм, нормативыг боловсруулах сангийн хөрөнгийг норм, нормативын бичиг баримтыг боловсруулах, шинэчлэх зорилгоор зарцуулна, БХБСайдын 2015 оны 5 дугаар сарын 15-ны өдрийн 108 дугаар тушаалаар батлагдсан “Барилгын норм, норматив боловсруулах санг бүрдүүлэх, зарцуулах журам”-ын 4.2.3 Байгууллага, хувь хүнийг ивээн тэтгэх арга хэмжээнд сангийн хөрөнгийг зарцуулахыг хориглоно гэж заалтуудтай нийцэхгүй байгаа тул менежментийн захидлаар зөвлөмж өгөв.

Арван нэг. Материаллаг бүс запруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар

Барилгын хөгжлийн төвийн 2015 оны санхүүгийн тайланд запруулагдаагүй материаллаг алдаа гараагүй байна.

Арван хоёр. Анхаарал татахуйц бусад чухал асуудал

Анхаарал татахуйц чухал асуудал үгүй байна.

Арван гурав. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд

Дараагийн аудитаар 2016 онд тохиож буй Шинэ үеийн барилгын салбар үүсч хөгжсөний 90 жилийн ойн арга хэмжээний үйл ажиллагаатай холбоотой асуудлыг авч үзэх.

Арван дөрөв. Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

Барилгын хөгжлийн төвийн 2015 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 30.9 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэнийг менежментийн захидлаар зөвлөмж өгөв.

Арван тав. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Барилгын хөгжлийн төвийн 2014 оны санхүүгийн тайланд Би энд Си аудит ХХК аудит хийж 2 зөвлөмж өгсөн бөгөөд 1 зөвлөмж нь биелүүлэх боломжгүй зөвлөмж байсан байна.

Арван зургаа. Зөвлөмж

Барилгын хөгжлийн төвийн 2015 оны санхүүгийн тайлангийн аудитаар 1 зөвлөмж өгч менежментийн захиалыг хавсаргав.

Арван долоо. Зөрчилгүй санал дүгнэлт

Барилгын хөгжлийн төвийн 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрнгүй, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн тайлангууд болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, НББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн бодитой, шударга илэрхийлэгдсэн байна.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН: САГ-ЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  С.ЭНХЗАЯА

АУДИТЫН МЕНЕЖЕР  Ц.ОЙДОВ

БЭЛТГЭСЭН: АУДИТОР  Ж.БОЛОРМАА



БАРИЛГЫН ХӨГЖЛИЙН ТӨВИЙН 2015 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Асуудал 1

- Норм, нормативын сангийн зарцуулалт

БАРИЛГЫН ХӨГЖЛИЙН ТӨВИЙН 2015 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Үндэсний аудитын газар аудитын явцад илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг Төсвийн шууд захирагчид зориулж бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал, горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмжийг өглөө.

Энэхүү менежментийн захидлын агуулга АОУС-ын дагуу хийгддэг ТАБ-ын аудитын горимоос урган гарсан болно. Бидний хэрэгжүүлсэн горим, сорил нь санхүүгийн тайлангийн санал дүгнэлт гаргахад зориулагдсан.

Тиймээс аудитын зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг тусгасан болно.

Төрийн аудитын байгууллагын энэхүү зөвлөмж нь та бүхний бүртгэл, тайлагнал, хяналтын үйл ажиллагааг сайжруулах зорилготой бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан Барилгын хөгжлийн төвийн холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

БАРИЛГЫН ХӨГЖЛИЙН ТӨВИЙН 2015 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

АСУУДАЛ 1: Норм, нормативын сангийн зарцуулалт

Ажиглалт

БХБСайдын 2015 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн 3/3225 дугаартай албан бичгээр Бельгийн Вант Улсад томилолтоор ажиллуулах 41.3 сая төгрөгийн зардал, тус яамны ТНБД-ын 2015 оны 11 дүгээр сарын 19-ний 3/3431 дугаар албан бичгээр ХБНГУ-ын Магдебург хотод томилолтоор ажиллах 30.9 сая төгрөгийн томилолтын зардал нийт 72.3 сая төгрөгийг Норм, нормативын сангийн хөрөнгөөс гаргасан байна.

“Ногоон хотууд-ногоон үйлдвэрлэл” олон улсын хуралд оролцох ажлын айлчлалын бүрэлдэхүүнд Сангийн үйл ажиллагаатай холбоогүй зарим нэг хүмүүс явсан бөгөөд айлчлалын зорилго Барилгын норм, норматив боловсруулах сангийн үйл ажиллагааны зорилготой нийцэхгүй байна.

Зөвлөмж

Барилгын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2 Барилгын норм, нормативыг боловсруулах сангийн хөрөнгийг норм, нормативын бичиг баримтыг боловсруулах, шинэчлэх зорилгоор зарцуулна, БХБСайдын 2015 оны 5 дугаар сарын 15-ны өдрийн 108 дугаар тушаалаар батлагдсан “Барилгын норм, норматив боловсруулах санг бүрдүүлэх, зарцуулах журам”-ын 4.2.3 Байгууллага, хувь хүнийг ивээн тэтгэх арга хэмжээнд сангийн хөрөнгийг зарцуулахыг хориглоно гэсэн заалтуудыг баримтлан ажиллах

Эрсдэл

Сангийн хөрөнгө зориулалтын дагуу зарцуулагдахгүй байх,

Үйлчлүүлэгчийн хариу

Аудитаар илэрсэн асуудлын бүртгэлийг танилцуулсан болно



**МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас: 26-04-37, Факс: 62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

Г БАРИЛГЫН ХӨГЖЛИЙН ТӨВИЙН
ЗАХИРАЛ Б.БАЯРСАЙХАН ТАНАА

2016.02.25 № 3/245
таний -ны № -т

Г Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Барилгын хөгжлийн төвийн 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн тайлан болон холбогдох бусад тайлбар тодруулга бүхий санхүүгийн тайланда аудит хийв.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Барилгын хөгжлийн төвийн удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бodoх бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв бэлтгэж, тайлагнах үүрэг хариуцлага хүлээнэ.

Барилгын хөгжлийн төвийн 2015 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан нь үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитыг Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журмын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журмын шаардлага нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэх явдал болно.

Аудитаар санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дун хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бodoх бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем, тэдгээрийг дэмжих нотлох зүйлийг сорилын үндсэн дээр шалгаж, удирдлагын хийсэн томоохон тооцооллыг үнэлж цэгнэн, санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлсэн.

Бидний хийсэн аудит санал дүгнэлт өгөх хангалттай бөгөөд зохистой үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

Зөрчилгүй санал дүгнэлт

Барилгын хөгжлийн төвийн 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн тайланг Нягтлан бodoх бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн, шударга илэрхийлсэн байна.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР С.ЭНХЗАЯА



АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	4,967,733,501.37	3,105,316,250.11
1.1.2	Дансны авлага	134,589,030.86	14,038,041.00
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	0.00	45,919,946.83
1.1.4	Бусад авлага	1,299,700.00	1,299,700.00
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө	0.00	0.00
1.1.6	Бараа материал	154,018,209.61	162,353,823.87
1.1.7	Урьдчилж төлсөн зардал тооцоо	0.00	0.00
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө	0.00	0.00
1.1.9	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)	0.00	0.00
1.1.20	Эргэлтийн хөрөнгийн дүн	5,257,640,441.84	3,328,927,761.81
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	1,539,164,929.36	6,067,651,070.54
1.2.2	Биет бус хөрөнгө	18,115,991.28	17,054,363.88
1.2.3	Биологийн хөрөнгө	0.00	0.00
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт	0.00	0.00
1.2.5	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө	0.00	0.00
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө	0.00	0.00
1.2.7	Хөрөнгө орлуулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө	0.00	0.00
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө	0.00	0.00
1.2.20	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	1,557,280,920.64	6,084,705,434.42
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	6,814,921,362.48	9,413,633,196.23
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	ӨР ТӨЛБӨР		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	327,022,393.40	134,717,044.13
2.1.1.2	Цалингийн өглөг	2,864,357.49	0.00
2.1.1.3	Татварын өр	116,591,163.07	13,946,684.10
2.1.1.4	НДШ-ийн өглөг	1,487,951.35	1,911,255.34
2.1.1.5	Богино хугацаат зээл	0.00	0.00
2.1.1.6	Хүүний өглөг	0.00	0.00
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг	0.00	0.00
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	17,875,069.00	17,480,069.00

2.1.1.9	Нөөц / өр төлбөр /	0.00	0.00
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	2,689,841,818.66	1,391,819,928.22
2.1.1.11	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)- нд хамаарах өр төлбөр	0.00	0.00
2.1.1.20	Богино хугацаат өр төлбөрийн дүн	3,155,682,752.97	1,559,874,980.79
2.1.2	Үрт хугацаат өр төлбөр		
2.1.2.1	Үрт хугацаат зээл	0.00	0.00
2.1.2.2	Нөөц / өр төлбөр/	0.00	0.00
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр	0.00	0.00
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр	0.00	0.00
2.1.2.20	Үрт хугацаат өр төлбөрийн дүн	0.00	0.00
2.2	Өр төлбөрийн нийт дүн	3,155,682,752.97	1,559,874,980.79
2.3	Эздийн өмч		
2.3.1	Төрийн өмч	8,159,338.00	8,159,338.00
2.3.2	Хувийн өмч	0.00	0.00
2.3.3	Хувьцаат өр төлбөр	0.00	0.00
2.3.4	Халаасны хувьцаа	0.00	0.00
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал	195,479,515.00	195,479,515.00
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	0.00	0.00
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	0.00	0.00
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	707,015,844.62	5,580,484,175.95
2.3.9	Хуримтлагдсан ашиг	2,748,583,911.89	2,069,635,186.49
2.3.20	Эздийн өмчийн дүн	3,659,238,609.51	7,853,758,215.44
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	6,814,921,362.48	9,413,633,196.23

АУДИТ ХИЙГДСЭН ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГЫН ТАЙЛАН

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн
1	Борлуулалтын орлого (цэвэр)	5,225,075,540.92	5,235,529,358.51
2	Борлуулалтын өртөг	43,062,123.75	25,803,723.14
3	Нийт ашиг (алдагдал)	5,182,013,417.17	5,209,725,635.37
4	Түрээсийн орлого	0.00	0.00
5	Хүүгийн орлого	158,163,575.45	159,338,667.05
6	Ногдол ашгийн орлого	0.00	0.00
7	Эрхийн шимтгэлийн орлого	0.00	0.00
8	Бусад орлого	0.00	0.00
9	Борлуулалт, маркетингийн зардал	0.00	0.00
10	Ерөнхий ба удирдлагын зардал	3,281,187,037.84	5,358,699,443.53

11	Санхүүгийн зардал	0.00	0.00
12	Бусад зардал	467,687,240.00	0.00
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	1,740,745.45	770,735.95
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	0.00	-2,647,823.06
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	0.00	0.00
16	Хөрөнгө орлуулалт борлуулсанаас үүссэн олз (гарз)	0.00	0.00
17	Бусад ашиг (алдагдал)	0.00	0.00
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	1,593,043,460.23	8,487,771.78
19	Орлогын татварын зардал	159,304,346.01	848,777.18
20	Татварын дараах ашиг (алдагдал)	1,433,739,114.22	7,638,994.60
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	0.00	0.00
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	1,433,739,114.22	7,638,994.60
23	Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00
23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэлийн зөрүү	0.00	0.00
23.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00
23.3	Бусад олз (гарз)	0.00	0.00
24	Орлогын нийт дүн	1,433,739,114.22	7,638,994.60
25	Нэгж хувьцаанд ноогдох суурь ашиг (алдагдал)	1,433,739,114.22	7,638,994.60

АУДИТ ХИЙГДСЭН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/төгрөгөөр/

	Үзүүлэлт	Өмч	Нэмж төлөгдсөн капитал	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2013 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	8,159,338.00	195,479,515.00	823,412,459.36	1,669,844,797.67	2,696,896,110.03
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	0.00	0.00	0.00	0.00	0.00
3	Залруулсан үлдэгдэл	8,159,338.00	195,479,515.00	823,412,459.36	1,669,844,797.67	2,696,896,110.03
4	Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00	0.00	0.00	0.00
5	Өмчид гаргасан өөрчлөлт	0.00	0.00	(116,396,614.74)	0.00	-116,396,614.74
6	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	355,000,000.00	355,000,000.00
7	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	0.00	1,433,739,114.22	1,433,739,114.22

8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	0.00	0.00	0.00	0.00	0.00
9	2014 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	8,159,338.00	195,479,515.00	707,015,844.62	2,748,583,911.89	3,659,238,609.51
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	0.00	0.00	0.00	0.00	0.00
11	Залруулсан үлдэгдэл	8,159,338.00	195,479,515.00	707,015,844.62	2,748,583,911.89	3,659,238,609.51
12	Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00	0.00	0.00	0.00
13	Өмчид гаргасан өөрчлөлт	0.00	0.00	4,873,468,331.33	(59,287,720.00)	4,814,180,611.33
14	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	627,300,000.00	627,300,000.00
15	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	0.00	7,638,994.60	7,638,994.60
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	0.00	0.00	0.00	0.00	0.00
17	2015 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	8,159,338.00	195,479,515.00	5,580,484,175.95	2,069,635,186.49	7,853,758,215.44

АУДИТ ХИЙГДСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	10,309,621,817.82	8,284,738,378.56
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсэний орлого	8,889,080,018.44	7,215,102,194.92
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	-	-
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	-	-
1.1.4	Буцаан авсан албан татвар	-	-
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	-	-
1.1.6	Бусад мөнгөн орлого	1,420,541,799.38	1,069,636,183.64
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	(9,446,142,889.86)	(10,164,525,032.82)
1.2.1	Ажиллагчдад төлсөн	(1,342,766,595.39)	(1,903,116,909.96)
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	(790,098,408.76)	(882,535,571.40)

1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	(5,951,520,193.13)	(4,945,752,384.01)
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	(55,397,499.73)	(82,132,358.10)
1.2.5	Түлш, шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	(2,108,100.00)	(52,223,400.00)
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн	-	-
1.2.7	Татварын байгууллагад төлсөн		

		(573,750,815.77)	(545,700,141.69)
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	-	(3,644,010.00)
1.2.9	Бусад мөнгөн зарлага	(730,501,277.08)	(1,749,420,257.66)
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	863,478,927.96	(1,879,786,654.26)
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	158,163,575.45	159,338,667.05
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсаны орлого	-	-
2.1.2	Биет бус хөрөнгө борлуулсаны орлого	-	-
2.1.3	Хөрөнгө оруулалт борлуулсаны орлого	-	-
2.1.4	Бусад урт хугацаат хөрөнгө боруулсаны орлого	-	-
2.1.5	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	-	-
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	158,163,575.45	159,338,667.05
2.1.7	Хүлээн авсан ногдол ашиг	-	-
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	(469,807,540.00)	(142,740,000.00)
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	(469,807,540.00)	(142,740,000.00)
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
2.2.3	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	-	-
2.2.4	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
2.2.5	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	-	-
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(311,643,964.55)	16,598,667.05

3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	2,244,897.47	2,242,355.92
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	-
3.1.2	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	-
3.1.3	Төрөл бүрийн хандив	-	-
3.1.4	Валютын ханшийн тэгшитгэлийн ашиг	2,244,897.47	2,242,355.92
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	(504,152.02)	(1,471,619.97)
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн		
3.2.2	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	-	-
3.2.3	Хувьцаа буцаан худалдаж төлсөн	-	-
3.2.4	Төлсөн ногдол ашиг	-	-
3.2.5	Валютын ханшийн тэгшитгэлийн алдагдал	(504,152.02)	(1,471,619.97)
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	1,740,745.45	770,735.95
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	553,575,708.86	(1,862,417,251.26)
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	4,414,157,792.51	4,967,733,501.37
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	4,967,733,501.37	3,105,316,250.11